



**МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/223

Мандалговь

Улсын үзлэг зохион байгуулах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дах заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагат хэрхэн хэрэгжиж байгаатай газар дээр нь танилцах, судалгаа хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- |                    |                |  |
|--------------------|----------------|--|
| Ажлын хэсэг дарга: | Л. Доржбат     | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)                                   |
| Зөвлөлийн гишүүд:  | Д.Цэвэлмаа     | (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)                                     |
|                    | Э.Цэвэлмаа     | (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга) |
|                    | П.Нямсүрэн     | (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч) |
|                    | Т.Урансайхан   | (Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)                               |
|                    | Б.Мөнхчулуун   | (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Позитивийн сургагч багш)       |
|                    | Ж.Зоригтбаатар | (Аймгийн ажил олгогч эздийн холбооны дарга)                                  |

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Улсын үзлэг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Улсын үзлэгийг удирдамжийн дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Л.Доржбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  М.АНХБАЯР



4800100-00